




Сургалтын сэдэв:  
Санал асуулгын  
хуудас  
боловсруулах нь



ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ  
Бизнесийн Удирдлага Хүмүүнлэгийн Сургууль

**ГОМБЫН ЦОЛМОН**

Бизнесийн удирдлагын  
салбарын ахлах багш

---

Улаанбаатар-49, ШХ-313  
Баянзүрх дүүрэг,  
ШУТИС-ийн V байр  
Вэб: [www.sbh.edu.mn/mn/](http://www.sbh.edu.mn/mn/)

Утас: -976-96602600  
E-mail: [tsolmon07@must.edu.mn](mailto:tsolmon07@must.edu.mn)

2020.01.17

---

## Агуулга


1. Асуулгын хуудас боловсруулах үе шат
2. Асуулгын хуудасны загварыг боловсруулах үе шат
  - Нэгдсэн төлөвлөгөө боловсруулах: Мэдээлэл цуглуулах аргыг сонгох, Асуулгын хуудасны бүтцийг тодорхойлох
  - Судалгааны зорилгыг тодорхойлох
  - Судлагдсан байдалтай танилцах
  - Асуултыг томъёолох: Асуултын хэлбэрүүд, Асуултыг илэрхийлэх, *Зайлсхийх асуултын төрлүүд*, Асуулгын хуудасны зохион байгуулалт
3. Асуулгын хуудсыг турших аргууд

---

## Асуулгын хуудас

- Хариулагчаас зорилтот сэдвийн хүрээнд мэдээлэл олж авахад чиглэсэн мэдээлэл цуглуулах болон харилцааны хэрэгсэл
- Сайн боловсруулсан асуулгын хуудас нь шаардлагатай мэдээллийг хамгийн бага алдааны түвшинд, үр ашигтай цуглуулах боломжийг олгох бөгөөд хангалтгүй боловсруулсан асуулгын хуудаснаас хамааралтай гарах алдааг мэдээлэл цуглуулсны дараагийн үе шатанд залруулах боломжгүй байдаг.
- Тийм учраас системчилсэн, үе шаттай боловсруулсан асуулгын дизайнтай байх, түүнийг турших нь мэдээллийн чанар болон хэмжилтийн алдааг бага байлгахад чухал ач холбогдолтой.

## Асуулгын хуудас боловсруулах үе шат



---

## 2. Асуулгын хуудасны загварыг боловсруулах үе шат

1. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.
2. Асуулгын хуудасны бүтцийг тодорхойлох
3. Судалгааны зорилгыг тодорхойлох
4. Судлагдсан байдалтай танилцах
5. **Асуултыг томъёолох**

---

## Асуултыг томъёолох

- Асуулгын хуудасны асуултыг хариулагч бүрэн ойлгож, хариулах хэмжээнд боловсруулна.
- Асуултууд нь тодорхой, зорилтот хүн амын бүх бүлгүүдэд ижил утгаар ойлгогдох, энгийн бөгөөд хоёрдмол утгагүй томъёологдсон байвал зохино.
- Судалгааны асуулт нь ойлгомжтой, оновчтой байна.
- Асуултуудыг сэдэв бүрт бүлэглэсэн байна. (sections)

---

## Асуултыг томъёолох. Асуултын хэлбэрүүд

- Нээлттэй асуулт нь хариултыг өгөгдсөн сонголтуудаас сонгохгүйгээр, өөрийн үгээр хариулах боломжийг хариулагчид олгоно.
- Нээлттэй асуулт нь тоон болон текстэн гэсэн 2 төрөлтэй.
  - Тоон утгаар хариулж болох нээлттэй асуулт: Та хэдэн настай вэ?\_\_
  - Бичгээр хариулж болох нээлттэй асуулт: Таны үндсэн ажил мэргэжил юу вэ?\_\_
  - Хаалттай асуулт нь боловсруулахад хялбар, хариултыг кодлож, нэгтгэхэд хялбар байна.

---

## Асуултыг томъёолох. Асуултын хэлбэрүүд

- *Шалгах асуулт*: Тухайн сэдвийн хүрээнд хариулах шаардлагатай эсэхийг тодорхойлоход хэрэглэнэ. Жишээ нь: зөвхөн малчин өрхүүдээс асуух бүлгийн эхэнд “Танайх мал аж ахуй эрхэлдэг үү?” гэж асууснаар мал аж ахуй эрхэлдэггүй өрхийг ялгаж болох юм.
- *Хагас хаалттай*: Хариултын тодорхой хувилбаруудыг санал болгохоос гадна "бусад", “тодорхойлж бичнэ үү” гэсэн сонголтыг олгоно. Хагас хаалттай асуултууд нь хариултын боломжтой хувилбаруудыг жагсааж гаргахад хүндрэлтэй үед илүү тохиромжтой.



---

## Асуултыг томъёолох.

### Асуултыг илэрхийлэх

- Хэл зүй болон үг хэллэг
- Асуултын хэмжээ болон цэг, таслал
- Асуултын заавар.

### Зайлсхийх асуултын төрлүүд

- Хоёрдмол утгатай асуултууд
- Чиглүүлэх болон тэнцвэргүй асуултууд

---

## Асуултыг томъёолох. Асуулгын хуудасны зохион байгуулалтыг тодорхойлох.

- Асуултын дараалал, бүлэглэлт
- *Шүүлтүүр асуултууд*. Бүлгийн асуултын эхэнд шүүлтүүр асуултыг байрлуулбал зохино.
- Асуултыг дараалуулахад эсрэг урсгал бүхий хоёр хэлбэрийг ашиглана. Энэ нь ерөнхий асуултаас тодорхой асуулт эсвэл эсрэгээрээ байна. Аль аргыг ашиглах нь судалгааны зорилгоос хамаарна.
- “Эмзэг асуулт”-ын байрлал ч бас чухал юм. “Эмзэг асуулт”-ыг асуулгын хуудасны эхэнд байрлуулбал хариултгүй асуултын тоог нэмэгдүүлж, хариулагч үлдсэн асуултыг үргэлжлүүлэн хариулах хүсэлгүй болох талтай байдаг. Тиймээс эмзэг асуултыг асуулгын хуудасны эхэнд байрлуулах шаардлагагүй байдаг.

---

### 3. Асуулгын хуудсыг турших аргууд

- Урьд өмнө нь асууж байгаагүй шинэ асуултуудыг томьёолох;
- Одоо ашиглаж байгаа асуулгын хуудсанд өөрчлөлт оруулах
- Асуулгын хуудсыг турших нь асуултуудын томьёолол, агуулга, дараалал/ сэдвийн нөлөөлөл, харагдах байдалтай холбогдон хариулагч, ярилцлага авагч хоёрын хэн хэнд нь гарч болох хүндрэлтэй асуудлыг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

---

## Судалгаанд оролцогчийг урамшуулах

- Хэрэглэгчийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мөнгөн ба мөнгөн бус хэлбэрийн урамшууллыг ашиглаж болно.
- Anonymity: Судалгаанд оролцогчийн хувийн мэдээллийг асуухгүй байх
- Confidentiality: Судалгаанд оролцогчийн хувийн мэдээллийг бусдад задруулахгүй байх

---

## Асуулгын хуудас боловсруулах үе шат

1. Судалгааны зорилгыг тодорхойлох
2. Анкет хэдэн хэсгээс бүрдэхийг тодорхойлох “section”
3. Хэмжилтийн нэгжийг сонгох
4. Асуулгын хуудасны асуулт, хариултыг томъёолох
5. Асуултыг үнэлэх
6. Асуултын дэс дарааллыг тодорхойлох
7. Асуулгын хуудсыг турших (test-pilot survey)
8. Захиалагчийн зөвшөөрлийг авах
9. Хариултын кодыг бэлтгэх
10. Асуулгын хуудсыг гүйцэд боловсруулах



Анхаарал хандуулсанд баярлалаа